

## Гадаад улсын нэрийн бичлэгийг тогтооход Ж.Цэвээний оруулсан хувь нэмэр

Мягмарсүрэнгийн ОДМАНДАХ<sup>ID</sup>

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм Хүмүүнлэгийн Ухааны Сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор /Ph.D/, дэд профессор, Улаанбаатар, Монгол Улс

Жамъяансүрэнгийн БАТБААТАР<sup>ID</sup>

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн ректор, доктор /Ph.D/, профессор, Улаанбаатар, Монгол Улс

SHUSHANG<sup>ID</sup>

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм Хүмүүнлэгийн Ухааны Сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн докторант. Улаанбаатар, Монгол Улс

Хүлээн авсан - Received:  
2024-10-21

Засварласан - Revised:  
2024-11-05

Хэвлэгдсэн - Published:  
2024-12-30

[odmandakh@msue.edu.mn](mailto:odmandakh@msue.edu.mn)

ORCID: [0009-0008-2461-760X](https://orcid.org/0009-0008-2461-760X)

[batbaatar@msue.edu.mn](mailto:batbaatar@msue.edu.mn)

ORCID: [0009-0007-3275-0040](https://orcid.org/0009-0007-3275-0040)

[uuree19900626@gmail.com](mailto:uuree19900626@gmail.com)

ORCID: [0009-0005-6382-1812](https://orcid.org/0009-0005-6382-1812)



© 2024, Author(s)

**Хураангуй:** Монгол улсад гарсан анхны тогтмол хэвлэл “Шинэ толь хэмээх бичиг” хэвлэгдсэн цагаасаа эхлэн гадаад улсын нэр, үгийг монгол хэлнээ хэрхэн буулгаж, бичиг тэмдэглэх талд үлгэр болж, хожим нь тухайн нэршлийг бичих жишиг болсон байна. Тухай сониныг эрхлэн гаргагч Жамсрангийн Цэвээн уг үүргийг гүйцэтгэж европын улс орнуудын нэр болон тухайн цагт хэрэглэгдэж байсан орчуулагдаагүй гадаад үгийг сонин хэвлэлдээ хэрхэн бичих, тэмдэглэх тухайд өөрөө үлгэрлэж байсныг сонины шарласан хуудас бидэнд харуулж байна. Ялангуяа гадаад улсын нэрийг олонхдоо Хятад ханзын дуудлагаар товчлон бичиж, хэрэглэх явдал байсан тул түүнийг тухайн үеийн улсынх нь нэрээр нэрлэн хэвшүүлэх ажлыг ч тус сонин түүчээлсэн байна.

**Түлхүүр үг:** *Шинэ толь хэмээх бичиг, гадаад үг, орчуулга, нэрийн галиг*

### Оршил

Монголчуудын анхны тогтмол хэвлэл “Шинэ толь хэмээх бичиг” сонин нь олон зүйлийн анхдагч болж, хожим хойтын сонин хэвлэлд үлгэр загвар болсон болох нь дараа дараагийн сонин хэвлэлийн байдлаас тодорхой харагддаг. Түүний нэг нь гадаад үгийг хэрхэн бичих, гадаад улсын нэрийг монгол хэлэнд зөв оновчтой тогтооход үлгэр загвар болсон гэхэд болно. “Шинэ толь хэмээх бичиг” сонины анхны дугаараас эхлэн гадаад улс орнуудын тухай бичнэ гэсэн редакцын бодлогоо баримтлан өгүүлэл, нийтлэлийг тогтмол нийтлэж иржээ.

Тухайн бичсэн өгүүлэл, нийтлэлдээ гадаад орны нэрийг Хятад улс хэрхэн нэрлэдгийг дурдаад монголоор өөрсдийн бичихийг дурдан бичсэн байдаг нь дараа дараагийн утга зохиолын хэл, нэр томъёо үүсэхэд ч чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

**Судалгааны арга зүй:** Энэхүү судалгаандаа түүврийн аргыг хэрэглэж, жишээ баримтыг сонины эх бичвэрээс сонгон авч, харьцуулан жишиж, задлан шинжилж, нэгтгэн дүгнэх аргуудыг голлон ашиглав. Сэтгүүл зүйн судалгаанд түгээмэл хэрэглэгддэг хүрээний онол, судалгааны арга зүй (Amartuvshin Sukhee, Tserenjav Tsevegjav, 2022) бичвэр судлалын харьцуулалтын арга (Лехачев, Д.С, 1983), задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргуудыг (Кумар, 2019), (Байгалмаа, Ч, 2015) ашиглаж, тус өгүүллийг бичив. Бид судалгаандаа хэрэглэсэн хүрээний аргыг Их Британийн нийгмийн судлаачид бодлогын судалгаанд ашигласан чанарын өгөгдөлд дүн шинжилгээ хийх арга болгон боловсруулсан (Willis, 2007) байдаг. Хүрээний онол, арга зүй нь социологи болон олон нийтийн харилцааны шинжлэх ухааны хүрээнд голлон ашиглагдаж, чанарын судалгааны үр дүнг тооцоход хэрэглэгддэг (Amartuvshin Sukhee, Tserenjav Tsevegjav, 2022, хууд. 3) байна. Тус

аргаар бид анхны тогтмол хэвлэлийн эхний дугааруудад гарсан улс орны нэрийг түүвэрлэн авч, агуулгын болон чанарын шинжилгээ хийв.

*Судалгааны эх хэрэглэгдэхүүн:* Судалгаандаа “Шинэ толь хэмээх бичиг” сонины анхны дугаар, түүнийг дахин хэвлэсэн эх, хоёр, гурав дахь дугааруудыг ашиглав. Ингэхдээ тухайн үед хэвлэгдсэн үндсэн эхийг PDF хэлбэрээр татаж судлагдахуун болгов.

*Судалгааны ажлын таамаглал:* Судалгаандаа бид дараах таамаглалыг дэвшүүлэв. Сониныг эрхлэн хэвлүүлэгч Ж.Цэвээн нь европ болон ази тивийн улс орны нэрийг хэрэглэхдээ Хятад хэл, ханзаар бичдэг тухайн үед тогтсон дорно зүгийн уламжлалыг барилгүй өөрийн ойлголт, сурц, хойд буриадад хэрэглэгдэж байсан уламжлалт бичлэгийн тиг хэлбэрийг шууд ашигласан болох нь тодорхой байна гэж үзэв. Энэ нь монголын утга зохиолын хэлэнд цаашид бичлэгийн хэлбэр нь тогтох, дараа дараагийн нэр томьёо тогтоох, хэрэглэхэд чухал нөлөө үзүүлсэн байна гэж таамаглав. Энэ таамаглалаа батлахын тулд “Шинэ толь хэмээх бичиг” сонины эхний дугаарын анхны хэвлэл болон дахин хэвлэсэн эхэд дурдагдсан дэлхийн улс орнуудын нэрийг түүвэрлэж, монгол бичгээр хэрхэн бичсэнийг эхээс нь зургийн хэлбэрээр татаж, мөн галигт буулгаж, хүснэгтлэн товчоолж, дараа нь бусад эх сурвалжуудтай харьцуулан дүн шинжилгээ хийлээ.

*Сэдвийн судлагдсан байдал:* “Шинэ толь хэмээх бичиг” сонины бичвэрт агуулгын бүрэн задлал хийсэн судалгаа өнөө хэр бүрэн бус байна. Сэтгүүл зүй судлаач, доктор Г.Дэлэг (Дэлэг.Г, 1965), доктор, профессор Л.Норовсүрэн (Норовсүрэн.Л, 2000), Т.Баасансүрэн (Баасансүрэн.Т, 2009), М.Одмандах (Одмандах.М, 2021) нарын судлаачид түүхийн бүтээлдээ нийтлэлийнх нь агуулгыг нэлээд дэлгэрэнгүй авч судалсан байдаг боловч гадаад үгс, улсын нэрийн талаар дурдан нарийвчилсан судалгаа хийгээгүй байна.

Харин нэр томьёо судлалын үүднээс хийсэн судалгаа манай улсад цөөнгүй байна. Тухайлбал, П.Бямбасан (Бямбасан.П, 1963), О.Адьяа (Адьяа.О, 2011), Л.Балдан (Балдан.Л, 2017), Г.Гэрэлмаа (Гэрэлмаа.Г, 2013), О.Шинэбаяр (Гэрэлмаа.Г, Шинэбаяр.О, Мөнхцэцэг.Н, Бат-Эрдэнэ.С, 2014), Д.Дашдаваа, Э.Равдан (Дашдаваа.Д, Равдан.Э, 1980) нарын зэрэг олон судлаач ном бүтээл туурвиж, судалгаа хийсээр байна.

Сэтгүүл зүй судлаач, доктор, дэд профессор Ч.Чойсамба “... *“Шинэ толь хэмээх бичиг” сонины мэдээнд (61) дурдагдсан гадаад улсуудын нэрсийг ажиглахад сонирхолтой. Дэлхийн нэгдүгээр дайны тухай мэдээнүүдэд гадаад улсуудын нэрс бусад мэдээнээс харьцангуй их тохиолдлоо. Эдгээр 8 мэдээнд нийт 13 улсын нэр тааралдаж буй бол бусад 53 мэдээнд ердөө 11 улсын нэр (Монголыг оруулаад) гарч байна. Энэхүү 53 мэдээнд хэрэв Монгол гэсэн нэр нэр 37, Орос 49, Хятад 20 удаа дурдагдсан бол давтамжаараа дараагийн гурван байрыг Америк (7 удаа), Мексик (7 удаа), Жибин (6 удаа) эзэлж буй юм. Зарим улсын нэрийн бичлэг одоогийнхоос харьцангуй өөр байсан нь монгол бичгийн эгшиг зохицох ёстой холбоотой аж: Германи, Австари, Ангали, Фарансус, Голанди г.м....”* (Чойсамба.Ч., 2023, р. 88) гэж гадаад улсуудын нэрийг хэрхэн бичиж байсанд ажиглалт хийжээ. Өөрөөр тус сонинд гарсан гадаад улсуудын нэр, гадаад үгийн талаар хийсэн ажиглалт судалгаа өнөө хэр алга байгаа нь уг сэдвийг сонгон судлах нэг үндэс болж байна.

Монгол бичгийн үсгийн дүрмийг цэгцлэх, нэгэн журамд оруулах толь бичгийн аль эртнээс улбаатай боловч 1921 онд Судар бичгийн хүрээлэн байгуулагдсаны дараахан орчин цагийн монгол хэлнийхээ дүрэм, журмыг эмхлэн найруулах, толь бичиг зохиох ажлыг өөрсдийн хүчээр хийх ажлыг эрчимжүүлсэн байдаг.

Энэ талаар Шагж “...*Тус Шинжлэхүй ухааны хүрээлэнгээс намайг үсгийн дүрмийн толь зохио хэмээн даалгасны дээр, би өөрийнхөөн ч намайг Монголын улс төр ба шинжлэх ухаан улмаар хөгжин дэлгэрч бүхий энэ үед үгийн баялаг ба үсгийн дүрэм чухал хэрэглэгдэх буй за хэмээснээр бичгийн үг, ардын ярианы үг, шинэ хөгжлийн үгсээс чинээгээр түүвэрлэж бичсээр энэхүү 27000 толгой үг бүхүй үсгийн дүрмийн толь бичгийг зохион бичив. Үүнийг ихэвчлэн бусад лугаа зөвлөлийг албан цагаас гадуур үйлдсэний тулд нэлээд ташаарал ба дутагдалтай болсон буй за.*

*Гэвч би гагцхүү энэ тухайг арван хэдэн жил оролдсон хүн тул үгийн баялагийг хураах талаар нэлээд арвин болсон байж бас ч болмуу...*” (Шагж.С, 1996, хууд. 886) гэж хэрхэн толь бичсэнээ тайлбарлаж, мөн цааш нь “... Үүний зохиогчид тус хүрээлэнгийн Азийн номын сангийн эрхлэгч Цэвэл нэлээд үг түүвэрлэн өгсөн ба, гадаадын аялгуут үгсийг нь Хяналгын комиссоос нөхөн оруулсныг тэмдэглэсүгэй...” (Шагж.С, 1996, хууд. 887) гэж байгаагаас үзэхэд тус толь нь хожмоо Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь”-ын дэвсгэр, суурь болсон болох нь харагдаж байна.

### ***Монголчуудын бичсэн газар зүйн бүтээлийн тухай товчхон***

Монголчууд эртнээс дэлхийн газар зүйн тухай өргөн мэдлэгтэй байсныг “Монголын нууц товчоо” зэргээс эхлээд мэдэж болно. Гэвч хожмын эрдэмтэн, мэргэдээс анхлан газар зүйн сурах бичиг, лавлах материалын түвшинд бичсэн хүн нь Сүмбэ хамба Ишбалжир юм. Тэрээр “... “Замбутивийн ерийн номлол” хэмээх нэг номыг 1777 онд зохиожээ. Одоогоор мэдэгдэж буйгаар энэ ном болбоос монгол хүн бичсэн хамгийн анхны дэлхийн газарзүйн ерөнхий мэдлэгийн ном болох юм...” (Данзанпэрэнлэй, 2016, р. х) гэж судлаач, доктор Б.Няммягмар бичсэн байна.

“...Сүмбэ хамба Ишбалжирын бичсэн энэхүү “Замбутивийн ерийн номлол” хэмээх зохиолыг дэлгэрүүлэн, урьд гарсан Тансан ламын “Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл”, Фа сяны ламын тэмдэглэл, Европын улсуудаас Бээжинд сууж байсан элчин төлөөлөгч болон шашин дэлгэрүүлэгчдийн ном сургаал, өөрсдийн тухайлан илгээсэн заншлаач бадарчингуудын мэдээ зангид тулгуурлан дахин нэг ном зохиогдсон нь 1830-1832 онд Миндол номун хан, Занба номун хан, Ганжуурва хутагт нарын хамтран бичсэн **“Замбутивийн дэлгэр номлол”** хэмээх ном юм...” (Данзанпэрэнлэй, 2016, р. xi) гэж судлаачид тэмдэглэсэн байна. Уг бүтээл нь одоогоос 200 орчим жилийн өмнө бичигдсэн боловч тухайн үедээ гар бичмэлээр Монгол нутагт тархсан байна.

Энэ үеэс эхлээд бид өрнө дорнын талаар нэлээд өргөн дэлгэр мэдээлэлтэй болж эхэлжээ. Уг бүтээлд орос хэлний нөлөө их туссан байгаа нь “... Орост төдийгүй өрнө дахинд монгол судлалын үндэс суурийг тавьсан Иосиф Михайлович Ковалевский 1829 онд Бээжинд зорин очжээ. Чухам энэ үед Их Хүрээгээр дайран Долоннуураар дамжин Бээжин орсон бөгөөд энэ аялынхаа явцад тэрээр Миндол номун хантай онцгой сайн харьцаа тогтоожээ. ... Энэхүү номд өрнө дахины тулхтай мэдээллийг нэлээдгүй өгч тусалсан О.М.Ковалевский Орост монгол судлалыг эхлүүлсэн хүн бөгөөд уг ном Манж Чин улсын газарзүйд үнэлж баршгүй мэдлэг, мэдээлэл хуримтлуулан оруулж, орчин үеийн ихээхэн баримжаатай газрын зургууд зурагдах эх суурийг тавьсан гэж хэлж болно...” (Данзанпэрэнлэй, 2016, хууд. xiv) гэж судлаачид тэмдэглэжээ.

Дээрх бүтээл нь өрнө, дорнын газар нутаг, улс орны нэрийг анх удаагаа маш өргөн хүрээнд мэдээлэл цуглуулж, өрнө, дорнын уламжлал, шинэчлэлийг хослуулан бичиж үлдээсэн газар зүйн чухал эх сурвалж юм. Өмнө нь дорно дахины уламжлалаар Энэтхэг, Хятад, Төвөдийн баримжаагаар, шашны онол, суртахууны үүднээс нэрлэж, өөрсдийн уламжлалт нэр томъёог бий болгож ашиглаж байсныг тус бүтээлд багтаан оруулсны дээр Оросын судлаач О.М.Ковалевскийн нөлөөгөөр өрнө дахины нэр, нэршлийг орос дуудлагаар авч ашигласнаараа анхдагч болж байна. “... Энэхүү номд орос хэлний нөлөө маш их оржээ. Орос гэдэг үгийг рүшисия, урус, орос зэргээр гурван янзаар бичсэн байна. Дэлхийн олон газрын нэрийн хойно орос хэлний “ское, ская” гэсэн хамаатуулах дагаварыг залгажээ. Тухайн үед буюу 1800-аад оны эхээр Оросын хаант улс маш том газар нутаг эзэмшилтэй байсан бөгөөд Манж Чин улстай их өргөн харилцаа холбоотой байжээ...” (Данзанпэрэнлэй, 2016, хууд. xiii) гэж судлаач, доктор Д.Няммягмар тэмдэглэсэн байна.

Манай орны хувьд Манжийн эрхшээлд байсан цагаас эхлэн Хятадын ханз үсэг, дуудлагын нөлөөгөөр зарим гадаад улсуудын нэрийг хятад маягаар хэрэглэх соёл дэлгэрсэн байсантай зэрэгцүүлэн өрнийн нэр, нэршлийг оруулж ирсэн нь тус номын гол ач холбогдол болж байна.

Дээрх номыг олон хүн хэрэглэж, нийтээрээ тухайн үг хэллэгийг мэддэг, хэрэглэж байсан гэхэд эргэлзээтэй юм. Гэвч “...Монголд 1830-1940 он хүртэл 100 гаруй жил дэлхийн газарзүйн гол сурах бичиг маягтай уншиж хэрэглэж байжээ. Академич Б.Ренчин “Монгол хэлний зүй” 1-р дэвтэртээ дурдсан бөгөөд Польш улсын тухай хэсэгт “Марусья ус уухуу хэмээх орон” гэх зэргээр бичсэн байна. Бидний хэрэглэсэн гурван төвөд эхэд ийм үг огт таарахгүй байгаагаас үзэхэд Б.Ренчин гуайн үзсэн эх нь олон дахин хуулагдсан мадагтай эх байсан бололтой...” (Данзанпэрэнлэй, 2016) гэснээс үзэхэд ямартаа нэлээд дэлгэрсэн эх байсан бололтой.

Ж.Цэвээн Богд хаант Монгол улсад ажиллаж, амьдарч байх үедээ өрний орнуудын талаарх газар зүйн бүтээл, сурах бичгийг орчуулж байсан мэдээ байна. Орчуулагч Д.Бадамням “...Ази, Европ, Америк, Австрали дөрвөн тивийн байдлыг орчуулж, орчлонт ертөнцийн байдлыг түүхчилэн үзүүлсэн гурван дэвтрийг зохион найруулж, зургийн хамт хэвлүүлжээ...” (Бадамням, Д., 2011, хууд. 45) гэж бичсэн нь түүний орчуулгын ажлын гол хэсэг нь сэдвийн хувьд газар зүйтэй шууд холбоотой байсныг харуулж байна. Тиймээс уг бүтээлд хэрэглэж байсан өрнө дахины улс орны нэрсийг Ж.Цэвээн тогтмол хэвлэлд анх удаагаа хэрэглэж, хятад дуудлагыг өрнийн нэртэй хослуулсан нь анхдагч зүйлийн нэг болж байсныг түүний эрхлэн гаргаж байсан “Шинэ толь хэмээх бичиг” сонины хуудаснаа харж болно. Энэ талаар бид тус өгүүлэлд хөндөн судлав.

### ***“Шинэ толь хэмээх бичиг”-ийн анхны дугаарт тэмдэглэгдсэн гадаад улсын нэрсийн байдал***

šin-e toli kemekü biçig /“Шинэ толь хэмээх бичиг”/ сонины анхны дугаараас эхлэн “Ертөнцийн төлөв байдал” [yirtencü-yin bayidal tülüb] (Цэвээн.Ж., 1913.03.06 [19], хууд. 3) гэсэн өгүүлэлд “...eseiy tib. ibrupa tib. aprig tib. amirig tib. abstarali tib...” хэмээн дурдаж эхэлснээс эхлэн улс орнуудын тухай өгүүлэл олноор нийтлэгдсэн байна. Мөн “Дэлхий дээрх олон улсын нэрс нь” [delekei degereki olun ulus-un neris anu] (Цэвээн.Ж., 1913.03.06 [19], хууд. 6) гэсэн өгүүлэлд дэлхийн улс орнуудын нэрийг дурдаж, аль улс нь хаана оршин байгааг товч тайлбарласан, дэлхийн газар зүйн тухай танин мэдэхүйн шинжтэй өгүүлэл хэвлэгдсэн байна.

Дээрх хоёр өгүүлэл нь “šin-e toli kemekü biçig” /“Шинэ толь хэмээх бичиг”/ сонины Оросын 1913 оны 3-р сарын 6 буюу Европын 3-р сарын 19-ний өдрийн анхны хэвлэл, 1913 оны 12-р сарын 20-ны өдөр буюу 1914 оны 1-р сарын 2-ны өдрийн хоёр дахь хэвлэлд улсын нэрийг хоёр янзаар буулгасан, өмнөх алдааг дараагийн хэвлэлд засаж, сайжруулсан болон хэвээр буулгасан зүйл ч олон байна. Энэ бүх байдал нь тухайн үед гадаад улс орны нэрийг бичихэд тодорхой тогтсон дүрэм байхгүй, зохиогч бүр өөрсдийн ойлголт, сурцаар бичиж, тэмдэглэж байсныг илтгэх бөгөөд түүнээс хойш 1920-оод оноос эхлэн нэгдсэн ойлголттой болж, бичлэгийн хувьд хэвшүүлсэн болох нь Шагжийн “Монгол хэлний үсгийн дүрмийн толь”-д хэрхэн журамласнаас харагдаж байна.





















Орчуулагч Д.Бадамнямын тэмдэглэсэн гадаад улсуудын тухай бүтээл энэ мөн бөгөөд анхлан сонинд хэвлэж түгээсэн нь тогтмол хэвлэлд гарсан хамгийн анхны дэлхийн газар зүйн тухай ойлголт, мэдээлэл болсны хувьд монголчуудын заримд нь шинэ мэдлэг, мэдээлэл болж байсан бөгөөд шинжлэх ухаан, танин мэдэхүйн үүрэг гүйцэтгэж байсан нь дамжиггүй юм.

Тэр бүрт дэлхийн улсуудын нэрийг тухайн үеийн бичлэгийн тиг онцлогийг харгалзан бичиж байсныг тодруулан судлах шаардлага бидэнд байна. Ингэснээр тогтмол хэвлэлд хожмоо хэрхэн бичиж хэвшсэнийг ч улируулан судлахад тустай болох юм. Бид энэ удаа “Шинэ толь хэмээх бичиг” сонины эхний дугаарыг болон дахин хэвлэгдсэн эхийг сонгон авч, түүнд бичигдсэн европын хэлний гадаад үгсийг түүвэрлэхээр хүрээ тогтоон ажиглалт, судалгаа хийлээ. Энэ нь дараа дараагийн сонин хэвлэлд хэрхэн бичигдэж үлдсэн хийгээд С.Шагжийн толь болон журамласан толиудад хэрхэн өөрчлөгдөж, хувьссаныг ч харах боломжтой юм.

***Хүснэгт №1. Гадаад улсын нэршил, галиг***

№	“Шинэ толь хэмээх бичиг” Дугаар №1	“Шинэ толь хэмээх бичиг” дахин хэвлэсэн эх	Мэндол Номун ханы “Замбутивийн дэлгэр номлол” бүтээлд	Шагжийн “Монгол хэлний үсгийн дүрмийн” тольд
<b>Европ тивийн улс орнуудын нэрс</b>				
1.	ᠠᠭᠢᠢ ᠲᠢᠪᠦ " eseiy tib	ᠠᠭᠢᠢ ᠲᠢᠪᠦ		ᠠᠭᠢᠢ
2.	ᠠᠵᠢ ᠲᠢᠪᠦ aji tib	ᠠᠵᠢ ᠲᠢᠪᠦ		
3.	ᠢᠪᠷᠠᠯᠢ ᠲᠢᠪᠦ " ibrupa tib	ᠢᠪᠷᠠᠯᠢ ᠲᠢᠪᠦ		
4.	ᠠᠫᠢᠷᠢᠭ ᠲᠢᠪᠦ aprig tib	ᠠᠫᠢᠷᠢᠭ ᠲᠢᠪᠦ	Африка [Eng. Africa (aa phe ra ka <A> aa pi ri ka <B>)]	ᠠᠫᠢᠷᠢᠭ
5.	ᠠᠮᠢᠷᠢᠭ ᠲᠢᠪᠦ amirig tib	ᠠᠮᠢᠷᠢᠭ ᠲᠢᠪᠦ		ᠠᠮᠢᠷᠢᠭ
6.	ᠠᠪᠰᠠᠷᠠᠯᠢ ᠲᠢᠪᠦ abstarali tib	ᠠᠪᠰᠠᠷᠠᠯᠢ ᠲᠢᠪᠦ		ᠠᠪᠰᠠᠷᠠᠯᠢ
7.	ᠠᠲᠯᠠᠭᠲᠠ atlangta	ᠠᠲᠯᠠᠭᠲᠠ		ᠠᠲᠯᠠᠭᠲᠠ
8.	ᠲᠠᠪᠠᠷ-ᠤᠨ tavar-un	ᠲᠠᠪᠠᠷ-ᠤᠨ		
9.	ᠠᠨᠭᠭᠠᠯᠢ anggali	ᠠᠨᠭᠭᠠᠯᠢ		ᠠᠨᠭᠭᠠᠯᠢ
10.	ᠢᠨᠭ ᠤᠯᠤᠰ ing ulus	ᠢᠨᠭ ᠤᠯᠤᠰ		
11.	ᠫᠢᠷᠠᠨᠭᠢᠰᠤᠰ parangsus	ᠫᠢᠷᠠᠨᠭᠢᠰᠤᠰ	Франкшия	ᠫᠢᠷᠠᠨᠭᠢᠰᠤᠰ
12.	ᠫᠠ ᠤᠯᠤᠰ pa ulus	ᠫᠠ ᠤᠯᠤᠰ		
13.	ᠵᠡᠭᠡ ᠣᠷᠤᠰ ᠤᠯᠤᠰ jeke orus ulus	ᠵᠡᠭᠡ ᠣᠷᠤᠰ ᠤᠯᠤᠰ	Рошисия [Eng. Russia (ro si siya)]	
14.	ᠰᠢᠪᠢᠷᠢ sibiri	ᠰᠢᠪᠢᠷᠢ		
15.	ᠬᠡᠶᠢᠪ keyib	ᠬᠡᠶᠢᠪ		
16.	ᠪᠤᠭᠠᠷ buqar	ᠪᠤᠭᠠᠷ		
17.	ᠳᠡ ᠤᠯᠤᠰ de ulus	ᠳᠡ ᠤᠯᠤᠰ		
18.	ᠭᠡᠷᠮᠠᠨᠢ ᠶᠡᠬᠡ ᠤᠯᠤᠰ germani-yin yeke ulus	ᠭᠡᠷᠮᠠᠨᠢ ᠶᠡᠬᠡ ᠤᠯᠤᠰ	Германия	
19.	ᠠᠤ ᠤᠯᠤᠰ au ulus	ᠠᠤ ᠤᠯᠤᠰ		
20.	ᠠᠪᠰᠠᠷᠢ ᠤᠯᠤᠰ abstari ulus	ᠠᠪᠰᠠᠷᠢ		ᠠᠪᠰᠠᠷᠢ
21.	ᠢᠲᠠᠯᠢ itali	ᠢᠲᠠᠯᠢ	Итали [Eng. Italy (ai thā li ya)]	
22.	ᠪᠢᠯᠭᠡᠢ bilgei	ᠪᠢᠯᠭᠡᠢ		
23.	ᠶᠣᠯᠠᠩᠳᠢ ᠶoolangdi	ᠶᠣᠯᠠᠩᠳᠢ	Нидерландия	ᠶᠣᠯᠠᠩᠳᠢ
24.	ᠳᠠᠨᠢ dani	ᠳᠠᠨᠢ	Дания	
25.	ᠢᠰᠫᠠᠨᠢ ispani	ᠢᠰᠫᠠᠨᠢ		
26.	ᠫᠣᠷᠲᠤᠶᠠᠯᠢ portuyali	ᠫᠣᠷᠲᠤᠶᠠᠯᠢ		
27.	ᠰᠢᠪᠢᠴᠠᠷᠢ sivičari	ᠰᠢᠪᠢᠴᠠᠷᠢ		

28.	ᠰᠢᠪᠠᠶᠢᠴᠢ	sivayiča	ᠰᠢᠪᠠᠶᠢᠴᠢ	Швеция	
29.	ᠨᠣᠷᠤᠪᠠᠶᠢᠭ	noruvayig	ᠨᠣᠷᠤᠪᠠᠶᠢᠭ		
30.	ᠷᠦᠮᠢᠨᠢ	rümini.	ᠷᠦᠮᠢᠨᠢ		
31.	ᠪᠣᠯᠶᠠᠷᠢ	bolyari.	ᠪᠣᠯᠶᠠᠷᠢ		
32.	ᠰᠡᠶᠢᠷᠪᠡ	seyirbe.	ᠰᠡᠶᠢᠷᠪᠡ		
33.	ᠴᠣᠷᠨᠠᠭᠦᠷᠢ	čornugüri.	ᠴᠣᠷᠨᠠᠭᠦᠷᠢ		
34.	ᠭᠡᠷᠢᠴᠡ	geriče.	ᠭᠡᠷᠢᠴᠡ		
<b>Ази тивийн улсуудын нэрс</b>					
35.	ᠲᠦᠷᠭᠡ	türge	ᠲᠦᠷᠭᠡ		
36.	ᠫᠢᠷᠰ	pars	ᠫᠢᠷᠰ		
37.	ᠠᠶᠢᠶᠠᠨᠢᠰᠠᠨ	avyanistan.	ᠠᠶᠢᠶᠠᠨᠢᠰᠠᠨ		
38.	ᠪᠢᠯᠡᠭᠡᠰᠠᠨ	bilejestan.	ᠪᠢᠯᠡᠭᠡᠰᠠᠨ		
39.	ᠲᠦᠪᠡᠳ	tubed	ᠲᠦᠪᠡᠳ		
40.	ᠡᠨᠡᠲᠡᠭᠡᠭ	enetkeg	ᠡᠨᠡᠲᠡᠭᠡᠭ		
41.	ᠪᠠᠯᠪᠤ	balbu.	ᠪᠠᠯᠪᠤ		
42.	ᠪᠦᠷᠢᠭᠦᠪᠡ	büriᠭve	ᠪᠦᠷᠢᠭᠦᠪᠡ		
43.	ᠶᠢᠵᠢᠳᠤᠳᠠᠳᠤᠳᠤᠸᠠᠨ	kitad- un dumdadu ulus	ᠶᠢᠵᠢᠳᠤᠳᠠᠳᠤᠳᠤᠸᠠᠨ		
44.	ᠵᠢᠪᠢᠨ	jiben	ᠵᠢᠪᠢᠨ	Жипин [Eng. Japan (zhvi bin)] Жапан [Eng. Japan (dza pa na)]	
45.	ᠭᠠᠤᠯᠢᠶᠢᠨ	yauli-yin ulus	ᠭᠠᠤᠯᠢᠶᠢᠨ	Гуули [Chin. (kvo li<A>gao li). Eng. korea] Корейя [Eng. Korea (gau ri ya<A>ko ri ya<c>)]	
46.	ᠰᠢᠶᠠᠮ	siyam	ᠰᠢᠶᠠᠮ		
47.	ᠠᠨᠠᠮ	anam	ᠠᠨᠠᠮ		
48.	ᠫᠢᠯᠢᠫᠢᠯᠢᠭ	piliping	ᠫᠢᠯᠢᠫᠢᠯᠢᠭ		
49.	ᠮᠢᠶᠤᠯᠤᠰ	miy ulus	ᠮᠢᠶᠤᠯᠤᠰ		
50.	ᠠᠯᠤᠨᠰᠢᠭᠢ	alünsᠭi	ᠠᠯᠤᠨᠰᠢᠭᠢ		
51.	ᠮᠢᠭᠰᠢᠭᠡ	migsige	ᠮᠢᠭᠰᠢᠭᠡ		
<b>Өмнөд Америк тив</b>					
52.	ᠪᠠᠷᠠᠵᠠᠶᠢᠯᠢ	barajayili	ᠪᠠᠷᠠᠵᠠᠶᠢᠯᠢ		



53.	 argingtin-a			
54.	 venucevele			
55.	 qolumbi			
56.	 paru			
57.	 çili			
58.	 bolivi			
59.	 panam-a			
<b>Африк тив</b>				
60.	 abisini		Абисиня [Eng. Abyssinya (aa bi sin a ya)]	
61.	 - igeyipet		Египет [Eng. Egypt (ae ka phid)]	
62.	 - dayumai			



**Гадаад улсын нэрсийг бичсэн байдалд  
хийсэн ажиглалт, судалгаа**

Сониныг эрхлэн хэвлүүлэгч Ж.Цэвээн нь тухайн үеийн Оросын гимнази, багшийн сургууль болон бусад сургуульд суралцаж, албан боловсрол эзэмшсэн байсан тул өрнийн соёлыг мэддэг, түүгээр боловсорсон байсан нь тодорхой юм. Тийм ч учраас түүний бичсэн дэлхийн байдал болон улс орнуудын тухай бичвэрүүд нь манай улсын иргэдийн хувьд шинэлэг, өмнө нь төдий л дуулж, сонсож байгаагүй сонин содон зүйл ихтэй байсныг тухайн үед уншигчдын гаргаж байсан хандлагаас харж болохоор байдаг. Энэ талаар И.Я.Коростовец болон Рамстед нар дурсамж, дуртгалдаа дурдан бичсэн байдаг билээ.

“Шинэ толь хэмээх бичиг” сонины анхны дугаар нь Оросын тооллын 1913 оны 3-р сарын 6-нд буюу европын тооллын 3-р сарын 19-ны өдөр Нийслэл хүрээнд хэвлэгдэн гарсан бөгөөд дахин 1913 оны 12-р сарын 20-ны өдөр буюу 2014 оны 1-р сарын 2-ны өдөр хэвлэгдсэн байдаг. Тус хоёр дугаарт хүртэл гадаад улсын нэрийг хоёр янзаар бичиж оруулсныг Хүснэгт №1-нээс тодорхой харж болно.

Энэ нь нэг талаар Ж.Цэвээн анхлан бичсэн гадаад улсын нэрсийг дахин засварлаж, дахин хэвлэсэн эхдээ зөв болгож оруулж, бичлэгийн хувьд жигдэлж, нэршлийг тодорхой болгосон зүйл ч их ажиглагдаж байна.

“Шинэ толь хэмээх бичиг” сонины эхний дугаарт орсон “Дэлхий дээрх олон улсын нэрс нь” [delekei degereki olun ulus-un neris anu] (Цэвээн.Ж., 1913.03.06 [19], хууд. 6) гэсэн өгүүлэлд 62 удаа гадаад улсын нэр дурдагдсан бөгөөд тэдгээрийг монгол хэлний бичлэгийн дүрмээр, монгол дуудлагаар голлон бичиж, заримыг нь орос, англи дуудлагаар нь буулгасан байна. Тухайлбал, “Ази тив” гэсэн үгийг нэг бичвэртээ дараах хоёр янзаар бичжээ.  eseyi tib гэж Англи дуудлагаар бичсэн бол мөн  aji tib гэж Монгол дуудлага, хэлбэрээр бичсэн байна.

Үүнийгаа харин дахин хэвлэхдээ  гэж өнөөгийн бидний хэрэглэдэг дуудлага, бичлэгээр оруулсан байна. Гадаад үгэнд ордог “з” үсгийг хэрэглэн бичсэн байгаа нь тухай үедээ  үсгийг албан хэрэгцээнд хэрэглэж байсан боловч бичигч нар өөрсдийн үзэмжээр бичиж тэмдэглэж байсныг харуулж байна.

Энэ мэтээр олон улсын нэрийг зөв хэвшүүлэхэд Ж.Цэвээн үнэтэй хувь нэмэр оруулсан бөгөөд өрнийн улсын нэрийг бичихдээ орчуулгын хамт хятад дуудлагаар нь давхар хадаж бичсэн байгаа нь аль алийг нь олон нийтэд ойлгомжтой байлгах, шинэ орчуулга, нэршлийг тогтооход нэгэнт хэвшсэн хуучин дуудлага, нэршлийг харьцуулан үзэхэд дөхөмтэй байсных юм.

Гадаад улсуудын нэрээс монголчуудын хамгийн их мэддэг цөөн гүрэн улсын нэрийг Хятад дуудлага болон улсын нэрийнх нь дуудлагаар давхар хэрэглэж байсан байна. Тухайлбал, Англи улсыг Ин улс, Франц улсыг Фа улс, Герман улсыг Дэ улс, Америк улсыг Мэй улс, Австри улсыг Ау улс гэж нэрлэж, бичиж байсан бол бусад улс орнуудын хувьд тухайн улсын нэрийг монгол аялгаар бичиж буулгаж, хэвшүүлэх эхлэлийг тавьсан байна.

**Хүснэгт №2. Гадаад улсын Хятад ханзын нэршил, галиг**

1.	ᠶᠢᠩ ᠤᠯᠤᠰᠢ ing ulus	ᠶᠢᠩ ᠤᠯᠤᠰᠢ
2.	ᠫᠠ ᠤᠯᠤᠰᠢ pa ulus	ᠫᠠ ᠤᠯᠤᠰᠢ
3.	ᠳᠡ ᠤᠯᠤᠰᠢ de ulus	ᠳᠡ ᠤᠯᠤᠰᠢ
4.	ᠠᠤ ᠤᠯᠤᠰᠢ au ulus	ᠠᠤ ᠤᠯᠤᠰᠢ
5.	ᠮᠢᠶᠢ ᠤᠯᠤᠰᠢ miy ulus	ᠮᠢᠶᠢ ᠤᠯᠤᠰᠢ

Мөн Япон улсыг Жибин улс гэж англи дуудлагыг монголчилон хэрэглэж, энэ нь хожуу үе хүртэл хэрэглэгдэж байсныг газрын зураг, сурах бичгээс үзэж болно. Харин Солонгос улсыг Гуулин улс гэж бичсэн байгаа нь эртний сурвалж бичигт тэмдэглэж, монголчуудын түгээмэл мэддэг нэр юм. Хожуу л бид Солонгос гэж нэрлэсэн болохоос бус тухайн үед ийм нэрээр нь л мэддэг байсан болно.

Ерөөс Ж.Цэвээн гадаад улсын нэршлийг тогтооходоо тухайн үеийн тогтсон тааллыг шууд эвдэлгүй, аажим нөлөөлөх замаар өрнийн улс орнуудын нэрийг хоногшуулах аргыг хэрэглэж, бичлэгийн хувьд ч монгол бичгийн хэлэнд ойртуулан бичиж, таниулж, аажмаар дүрэмд захируулан зөв хэлбэршүүлэхэд анхаарсан болох нь харагдаж байна. Зарим нэршлийг сонины эхний хэвлэлтэд буруу бичсэн бол дараагийн хэвлэлтэд засаж, зөв болгосон зүйл ч их байгаа нь Ж.Цэвээн бичсэн зүйлээ дахин сайжруулж, нягталж, алдааг залруулдаг байсны илрэл юм.

Нэгэнт тогтсон толь хараахан гараагүй, зохиогч бүр өөрсдийн мэдлэг, чадварын хүрээнд бичиж тэмдэглэж, монгол хэлний эгшиг зохицох ёсыг харгалзан бичиж байсныг дээрх бичвэр дэх бичлэгээс тодорхой харж болно.

Тухайлбал, эгшиг зохицох ёс болон гийгүүлэгч үсгийг монгол дуудлага, бичлэгээр нь бичсэн улсын нэрс:

**Хүснэгт №3. Монгол бичгийн эгшиг зохицох ёсоор тохируулан бичсэн улсын нэрс**

1.	ᠡᠰᠡᠶᠢ ᠲᠢᠪᠦ eseiy tib	ᠡᠰᠡᠶᠢ ᠲᠢᠪᠦ	19.	ᠰᠡᠶᠢᠷᠪᠡ seyirbe.	ᠰᠡᠶᠢᠷᠪᠡ
2.	ᠠᠵᠢ ᠲᠢᠪᠦ aji tib	ᠠᠵᠢ ᠲᠢᠪᠦ	20.	ᠭᠡᠷᠢᠴᠡ geriče.	ᠭᠡᠷᠢᠴᠡ
3.	ᠠᠮᠢᠷᠢᠭ ᠲᠢᠪᠦ amirig tib	ᠠᠮᠢᠷᠢᠭ ᠲᠢᠪᠦ	21.	ᠲᠦᠷᠭᠡ түрге	ᠲᠦᠷᠭᠡ
4.	ᠠᠪᠰᠢᠷᠠᠯᠢ ᠲᠢᠪᠦ abstarali tib	ᠠᠪᠰᠢᠷᠠᠯᠢ ᠲᠢᠪᠦ	22.	ᠲᠦᠪᠡᠳᠦ tubed	ᠲᠦᠪᠡᠳᠦ
5.	ᠠᠲᠯᠠᠭᠲᠠ atlangta	ᠠᠲᠯᠠᠭᠲᠠ	23.	ᠡᠨᠡᠲᠭᠡ enetkeg	ᠡᠨᠡᠲᠭᠡ
6.	ᠠᠩᠭᠠᠯᠢ anggali	ᠠᠩᠭᠠᠯᠢ	24.	ᠪᠠᠯᠪᠤ balbu.	ᠪᠠᠯᠪᠤ
7.	ᠵᠡᠭᠡ ᠣᠷᠤᠰᠤ ᠤᠯᠤᠰᠢ jeke orus ulus	ᠵᠡᠭᠡ ᠣᠷᠤᠰᠤ ᠤᠯᠤᠰᠢ	25.	ᠬᠢᠲᠠᠳᠤ ᠤᠨ ᠳᠤᠮᠳᠠᠳᠤ ᠤᠯᠤᠰᠢ kitad-un dumdadu ulus	ᠬᠢᠲᠠᠳᠤ ᠤᠨ ᠳᠤᠮᠳᠠᠳᠤ ᠤᠯᠤᠰᠢ



8.	ᠰᠢᠪᠢᠷᠢ sibirī	ᠰᠢᠪᠢᠷᠢ	26.	ᠵᠢᠪᠡᠨ jiben	ᠵᠢᠪᠡᠨ
9.	ᠬᠡᠶᠢᠪ keyib	ᠬᠡᠶᠢᠪ	27.	ᠶᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶauli-yin ulus	ᠶᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠤᠯᠤᠰ
10.	ᠪᠤᠭᠠᠷ buqar	ᠪᠤᠭᠠᠷ	28.	ᠰᠢᠶᠠᠮ siyam	ᠰᠢᠶᠠᠮ
11.	ᠭᠡᠷᠮᠠᠨᠢ ᠶᠢᠨ ᠶᠡᠬᠡ ᠤᠯᠤᠰ germani-yin yeke ulus	ᠭᠡᠷᠮᠠᠨᠢ ᠶᠢᠨ ᠶᠡᠬᠡ ᠤᠯᠤᠰ	29.	ᠠᠨᠠᠮ anam	ᠠᠨᠠᠮ
12.	ᠠᠪᠰᠠᠷᠢ ᠤᠯᠤᠰ abstari ulus	ᠠᠪᠰᠠᠷᠢ	30.	ᠠᠯᠦᠨᠰᠭᠢ alünsgi	ᠠᠯᠦᠨᠰᠭᠢ
13.	ᠶᠢᠲᠢᠯᠢ itali	ᠶᠢᠲᠢᠯᠢ	31.	ᠮᠢᠭᠰᠢᠭᠡ migsige	ᠮᠢᠭᠰᠢᠭᠡ
14.	ᠪᠢᠯᠭᠡᠢ bilgei	ᠪᠢᠯᠭᠡᠢ	32.	ᠪᠠᠷᠠᠵᠠᠶᠢᠯᠢ barajayili	ᠪᠠᠷᠠᠵᠠᠶᠢᠯᠢ
15.	ᠶᠤᠯᠤᠭᠠᠨᠳᠢ ᠶoolangdi	ᠶᠤᠯᠤᠭᠠᠨᠳᠢ	33.	ᠠᠷᠭᠢᠨᠲᠢᠨᠠ ᠠ argingtin-a	ᠠᠷᠭᠢᠨᠲᠢᠨᠠ ᠠ
16.	ᠳᠠᠨᠢ dani	ᠳᠠᠨᠢ	34.	ᠶᠤᠯᠤᠮᠪᠢ qolumbi	ᠶᠤᠯᠤᠮᠪᠢ
17.	ᠷᠦᠮᠢᠨᠢ rümini.	ᠷᠦᠮᠢᠨᠢ	35.	ᠴᠢᠯᠢ čili	ᠴᠢᠯᠢ
18.	ᠪᠣᠯᠶᠠᠷᠢ bolyari.	ᠪᠣᠯᠶᠠᠷᠢ			

Эдгээр 35 улсын нэрийг монгол бичгийн эгшиг зохицох ёсны дагуу бичсэн байгаа бөгөөд 1920-оод гарсан хэвлэл, толь бичигт гадаад үгийг бичих дүрмийн дагуу бичлэгийг тогтоон хэрэглэх болсон байна.

Ж.Цэвээний тус сонинд нийтлүүлсэн “Ертөнцийн төлөв байдал” [yirtencü-yin bayidal түлүб] (Цэвээн.Ж., 1913.03.06 [19], хууд. 3), “Дэлхий дээрх олон улсын нэрс нь” [delekei degereki olun ulus-un neris anu] (Цэвээн.Ж., 1913.03.06 [19], хууд. 6) гэсэн бичвэрүүд нь гадаад улсын нэрийг монголчуудад таниулах, бичлэгийн хэлбэрийг тогтооход чухал хувь нэмэр оруулсан бөгөөд өрнийн боловсрол, мэдлэгийг олгоход чиглэгдсэн танин мэдэхүйн шинжтэй, сурах бичгийн хэлбэртэй шинэ мэдлэг олгоход чиглэгдсэн байжээ.

### Дүгнэлт

Монголын анхны тогтмол хэвлэл “Шинэ толь хэмээх бичиг” сонин, сэтгүүл нь гадаад улсуудын нэр, гадаад үгийг хамгийн анх хэвлэн нийтлэсэн анхдагч болох нь судалгаанаас тодорхой байна. Дэлхийн улс орнуудын газар зүйн тухай ойлголтыг олон нийтэд зориулан монгол бичгээр гаргасан анхны хэвлэл мөн байна.

Дэлхийн улс орнуудын тухай бичвэрийг сониныг эрхлэн гаргагч Ж.Цэвээн бичсэн болох нь түүний бусад бүтээлтэй харьцуулан шинжлэхэд тодорхой харагдаж байна. Бусад судлаачдын бүтээлд ч түүний орчуулгын тухай дэлгэрэнгүй дурдсан зүйлд тус сонинд гарсан бүтээлийн агуулга багтаж байгаа нь хөдөлбөргүй нотлож байна.

Гадаад улс орны нэрийн бичлэгийг хэвшүүлэхэд тус сонин голлох үүрэг гүйцэтгэж, тухайн цаг үеийн хэлний байдлыг илтгэж байна гэж дүгнэж болохоор байна. Энэ нь нэгдсэн барьдаг толь байхгүйгээс болж монгол хэлний эгшиг зохицох ёсоор бичиж, тэмдэглэж байсан нь баримтуудаас тодорхой байна.

Хожим нь С.Шагжийн толь бичиг гарч, бичлэгийг жигдлэх хүртэл янз бүрээр бичиж байсныг дээрх сонины жишээ илтгэж байгаа боловч Хятадын ханзаар бичигддэг, хятадаар дуудагддаг дуудлагыг европ хэлний, тэр дундаас орос хэлний нөлөө ихтэй байгаа нь Ж.Цэвээний хэлний чадвар, боловсрол, мэдлэг боловсролтой нь холбоотой байна.

## J.Tseveen's contribution to the standardization of foreign name records

ODMANDAKH Myagmarsuren 

Ph.D., Associate Professor, Head of the Department of Journalism, School of Humanities and Social Sciences, Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia.

BATBAATAR Jamiyansuren 

Ph.D., Professor, Rector of Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia.

SHUSHANG 

Doctoral student, Department of Journalism, School of Humanities and Social Sciences, Mongolian National University of Education. Ulaanbaatar, Mongolia.

### Summary

Since its publication, the first regular periodical in Mongolia, “Shine Toli” (New Mirror), has served as a model for how to translate and write foreign names and words into the Mongolian language, establishing a standard for writing those names later on. The editor of the newspaper, Jamtsran's Tseveen, played a significant role in demonstrating how to write and record the names of European countries and foreign words that were not translated at that time in the newspaper.

The yellowed pages of the publication show us that he set an example in this regard. Notably, the names of foreign countries were often abbreviated using the Chinese characters' pronunciations, and the newspaper also took the initiative to establish these names in accordance with the names used in those countries at the time.

**Key words:** “Shine Toli”, foreign words, translation, name transliteration

### Ном зүй

Sukhee, A., & Tsevegjav, T. (2024). Framing studies: stereotypes about Mongolia’s in the American Press (1868–1968). *Cogent Arts & Humanities*, 11(1).  
<https://doi.org/10.1080/23311983.2024.2303178>

Willis, J. W. (2007). *Foundations of qualitative research: Interpretive and critical approaches*. SAGE Publications, Inc., <https://doi.org/10.4135/9781452230108>

Адъяа.О. (2011). *Сопоставительное терминоведение*. УБ.

Баасансүрэн.Т. (2009). XX зууны эхэн үеийн монголын чөлөөт хэвлэл /Тэргүүн дэвтэр/. *Монголд чөлөөт хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь*. УБ.

Бадамням.Д. (2011). Гарамгай дуун хөрвүүлэгч Жамцараны Цэвээн. *Их соён гэгээрүүлэгч Жамсраны Цэвээн*. УБ: "ААББ" ХХК.

Байгалмаа.Ч. (2015). *Боловсролын судалгааны арга зүй*. УБ.

Балдан.Л. (2017). *Монгол хэл, нэр томъёо, найруулга зүйн судалгаа*. УБ.

- Бямбасан.П. (1963). Оноосон нэрийн тухай. Хэл зохиол. ШУА, *Эрдэм шинжилгээний өгүүллүүдийн эмхтгэл*. УБ: ШУАХ.
- Гэрэлмаа.Г. (2013). Орчин үе ба нэр томъёоны толь. *Хэл зохиол*, 6 (38).
- Гэрэлмаа.Г, Шинэбаяр.О, Мөнхцэцэг.Н, Бат-Эрдэнэ.С. (2014). *Монгол нэр томъёо судлалын товчоон*. УБ.
- Данзанпэрэнлэй, М. Н. (2016). *Өмнөх замбутивийн байр байцыг дэлгэр номлосон тодорхой толь*. (Хянасан Няммыгмар.Б.) УБ.
- Дашдаваа.Д, Равдан.Э. (1980). *Нэр томъёоны тухай*. УБ: УХГ.
- Дэлэг.Г. (1965). *Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл*. УБ: УХХЭХ.
- Кумар, Р. (2019). *Сэтгэл судлалын судалгааны арга зүй*. УБ.
- Лехачев.Д.С. (1983). *ТЕКСТОЛОГИЯ: НА МАТЕРИАЛЕ РУССКОЙ ЛИТЕРАТУРЫ X—XVII ВЕКОВ*. Ленинград: "НАУКА" ЛЕНИНГРАДСКОЕ ОТДЕЛЕНИЕ.
- Норовсүрэн.Л. (2000). *Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм /Тэргүүн дэвтэр/*. УБ.
- Одмандах.М. (2021). *Монголын анхны тогтмол хэвлэлийн түүхийн судалгаа*. УБ: Жиком пресс ХХК.
- Цэвээн.Ж. (1913.03.06 [19]). Дэлхий дээрх олон улсын нэрс нь. *Шинэ толь хэмээх бичиг*.
- Цэвээн.Ж. (1913.03.06 [19]). Ертөнцийн төлөв байдал. *Шинэ толь хэмээх бичиг*.
- Чойсамба.Ч. (2023). Орчин үеийн сэтгүүл зүйн асуудал. Чойсамба.Ч., & Болд-Эрдэнэ.Б. (Хян.), *"Шинэ толь хэмээх бичиг" сонины мэдээний онцлог*. Улаанбаатар хот.
- Шагж.С. (1996). *Монгол үсгийн дүрмийн толь*. УБ: Монгол Улсын Соёлын сан.